



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ӨНДӨРШИЛ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ

2022 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 81

Бөхт

Сумын орон нутгийн тусгай хамгаалалтанд
авах газар нутгийн жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн 20.1.3 дахь заалт, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 28 дугаар 28.3 дахь хэсэг, Усны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийн 11.1.3 дахь заалт, Байгаль орчны сайдын 2020 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтад авах тухай журам”-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Өндөршил сумын орон нутгийн тусгай хамгаалалтад авах газар нутгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газрын материалыг Ашигт малтмал, газрын тосны газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газарт хүргүүлж бүртгэлжүүлэн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумын Засаг дарга (У.Алтанхүү)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга (Д.Уранбилэг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.МӨНХЦЭЦЭГ

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 81 дүгээр тогтоолын хавсралт



ДУНДГОВЬ АЙМГИЙН ӨНДӨРШИЛ СУМЫН ОРОН НУТГИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАНД
АВАХ ГАЗАР НУТГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Газрын нэр	Газрын солбицол WGS84/ Zone 49N			Газрын хэмжээ /га/	Хамгаалалтанд авах шаардлага	Хамгаалалтанд авсан шалтгаан	Хамгаалал- танд авсан хугацаа /жил/
		№	x	y				
1	Зүрхийн цагаан хүрээ	1	45°31'46.02"	108°22'3.30"	50	Дурсгалт газар	Булш оршуулгын газар	60
		2	45°32'1.00"	108°22'35.86"				
		3	45°31'38.94"	108°22'45.41"				
		4	45°31'28.51"	108°22'17.54"				
2	Ширүүн ухаа	1	45 13 2.702	108 16 35.182	20	Дурсгалт газар	Булш оршуулгын газар	60
		2	45 13 3.348	108 3 52.782				
		3	45 12 52.461	108 17 2.935				
		4	45 12 51.783	108 16 35.704				